



ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН  
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХК

# ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

## **ХЭМАБ-ЫН ЗОРИЛГО, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨЛТ**

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэх зорилго, төлөвлөгөөг компанийн хэмжээнд боловсруулж, нэгж, хэсгүүдийн түвшинд хэрэгжүүлж, гүйцэтгэлийг тогтмол хянаж, сайжруулна.

Компани нь ХЭМАБ-ын зорилгоо (2021-2024 он) дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- 4.2.1 Хөдөлмөрийн эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөдөлмөрийн чадвар түр алдалт, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн дундаж үзүүлэлтийг 10% -иар бууруулна.
- 4.2.2 Ажилтан нэг бүрийн ядаргааны түвшинг тодорхойлж, ядаргааны менежментийг боловсруулж нойргүйдэл, стресс, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх хөтөлбөрийг боловсруулж эрүүлжүүлнэ.
- 4.2.3 Үйл ажиллагааны ХЭМАБ-ын эрсдлийн үнэлгээнд эрүүл мэндийн эрсдлийн түвшинг оруулан үнэлж эрсдлийн түвшинг 15% -иар бууруулна;
- 4.2.4 Аюулыг илрүүлэх, мэдээлэх, устгах, эрсдлийг үнэлэх, тогтолцоог тасралтгүй сайжруулна.
- 4.2.5 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, осолд дөхсөн тохиолдлыг бүртгэж, хүний амь нас, хөдөлмөрийн чадвар алдахуйц аюултай тохиолдлын тоог тэглэнэ.
- 4.2.6 ХЭМАБ-ын дотоод аудитыг тогтмолжуулж, илэрсэн үл тохирлыг залруулах, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай нөөцөөр хангана.

### **Өөрчлөлтийн төлөвлөлт**

Компани ХЭМАБ бодлогыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх зорилгын хүрээнд ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоонд шаардлагатай өөрчлөлтийг оруулж болох ба үүний тулд өөрчлөлтийг төлөвлөнө.

4.3.1 Энэхүү шаардлагатай өөрчлөлт нь дараах зүйлийг авч үзнэ. Үүнд:

- a. Өөрчлөлт оруулах зорилго, түүнээс гарах үр дагавар;
- b. ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны уялдаа, нэгдмэл байдал;
- c. Нөөцийн боломж;
- d. Үүрэг хариуцлага, эрх мэдлийн хуваарилалт, өөрчлөн хуваарилалт.